

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны ... дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 12 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын тайлан

“12.1.Засгийн газар байгаль орчны төлөв байдлын тайланг хоёр жилд тутамд гаргаж Монгол Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн мэдүүлэх бөгөөд тайланд байгаль орчны төлөв байдал, байгалийн баялгийн нөөц, түүний хувьсал өөрчлөлт, байгалийн баялгийн ашиглалт, түүнээс олсон орлого болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг бууруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг тусгана.”

2/ 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“14.5.Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн баримтлах журмыг батлах.”

3/ 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“16.1.7.Нутаг дэвсгэрийнхээ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөнд туссан байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс тухайн орон нутгийн төсөвт тусган баталж, зарцуулалтад хяналт тавих.”

4/ 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

26.1/1.Байгаль орчны хяналтын ерөнхий байцаагч нь Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.”

5/ 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 23 дахь заалт:

“35.1.23.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн мэдээлэл”.

6/ 37 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

“37.9.Энэ хуулийн 36<sup>1</sup> дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улирал бүр, 1.3-т заасан мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллага улсын мэдээллийн санд улирал бүр оруулна.”

7/ 49 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:

“9.Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгө, байгалийн нөөцөд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг төвлөрүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.”

8/ 54 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт:

“1/ Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан, байгальд ээлтэй түүхий эд материал ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд олгох “Эко тэмдэг”-ийн шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал болон Ногоон

гэрчилгээ, Эко тэмдгийн гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**2 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтын “зорилготой” гэсний дараа “Иргэний хуулийн 25.1-д заасан шинжийг агуулсан хуулийн этгээд, 481.1-д заасан”, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “нийслэлийн” гэсний дараа “сум дүүргийн”, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад “нийслэлийн” гэсний дараа “сум дүүргийн”, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын “засаж тохижуулсан газар” гэсний дараа “булаг, шанд”, 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “...бороохой” гэсний дараа “нэг хүнд нөлөөлөх”, 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “туслалцаа үзүүлсэн” гэсний дараа “нөхөрлөл, төрийн бус байгууллага” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт:

“7.нутаг дэвсгэрийнхээ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөнд туссан байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс санхүүжүүлж, шаардлагатай бусад дэмжлэгийг үзүүлж ажиллах.”

2/ 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7.нутаг дэвсгэрийнхээ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөнд туссан байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс тухайн орон нутгийн төсөвт тусган баталж, хэрэгжилтэнд хяналт тавих.”

3/ 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/2.нөхөрлөлийн гэрээгээр хариуцан хамгаалж байгаа газар нутагт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийг олгохдоо тухайн харилцаанд оролцож буй этгээдтэй зөвшилцөх.”

4/ 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4/.Цацраг идэвхт болон химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам, аюултай болон энгийн хог хаягдалтай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.”

5/ 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалт:

“26.4.1.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.4-т заасны дагуу “ гэсний дараа “Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн.”

6/ 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“29.1.Улсын байцаагч, байгаль хамгаалагч нь хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгслийг Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2-т заасны дагуу хэрэглэнэ.”

7/ 50 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“50.7.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь үйл ажиллагаагаа Төрийн бус байгууллагын тухай хуульд нийцүүлэн эрхэлнэ.”

8/ 50 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:

“50.14.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ, тэмдэг олгох журмыг Байгаль орчны болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, бүртгэлийг Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу бүртгэнэ.”

9/ 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“54.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд үзүүлэх хортой, аюултай нөлөөллийг багасгах, хаягдалгүй дэвшилтэт арга, технологи нэвтрүүсэн, байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг төрөөс дэмжиж урамшуулна.”

**4 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Мэргэжлийн хяналтын” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төрийн захиргааны төв байгууллага батална” гэснийг “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг Монгол Улсын Ерөнхий прокурор болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж, 48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “11” гэснийг “8” гэж, 54 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “байгаль хамгаалагчид” гэснийг “идэвхтэн байгаль хамгаалагчид” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтын “боловсруулан”, 55 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “журмыг”, 54 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “улсын байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллага”, 54 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн “цагдаа, хил хамгаалах байгууллагын ажилтан” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 болон 2 дахь заалт, 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:

“17.2.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 17.1 дэх хэсэгт заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.”

**2 дугаар зүйл.** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “... ус ...” гэсний дараа “... рашаан,” 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “... агнасан ...” гэсний дараа “,барьсан ...” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “... агнахад ...” гэсний дараа “... аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ... ” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17.1.5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“17.1.5.тусгай төлбөртэйгөөр агнуулсан, бариулсан ан амьтны нөөцийн төлбөрийг энэ хуулийн 12.1.6-д заасан жишиг үнийн 80-90 хувиар;”

**4 дүгээр зүйл.** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн гарчгийг “Ойн нөөц ашигласны төлбөр ноогдох зүйл” гэснийг “Ойн баялаг ашигласны төлбөр ногдох зүйл” гэж, 11 дүгээр зүйлийн гарчгийг “Ойн нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт” гэснийг “Ойн баялаг ашигласны төлбөр тооцох үзүүлэлт” гэж, 12.1.6 дахь заалтын “эрх бүхий байгууллагаас” гэснийг “Засгийн газраас” гэж, 13.4 дэх хэсгийн “... сумын ...” гэснийг “... сум, дүүргийн ...” гэж, 16 дугаар зүйлийн гарчгийг “Ойн нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ” гэснийг “Ойн баялаг ашигласны төлбөрийн хувь, хэмжээ” гэж, 16.5 дахь хэсгийн “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Засгийн газар” гэж, 17.1.6 дахь заалтын “гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон” гэснийг “энэ хуулийн 12.1.6-д заасан” гэж, 21 дүгээр зүйлийн гарчгийг “Ойн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх” гэснийг “Ойн баялаг ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.2.5, 18.1.3 дахь заалтаас “нөөцийн” гэдгийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.  
ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Агаарын тухай хуулийн 9.1.10 дах заалтын “мэдэгдэх” гэсний дараа “нөхөн төлбөр авах” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дүгээр  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭМЭГДСЭН ӨРТӨГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсгийн "...болон зочид буудлын..." гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмсүгэй:

“8.3.Аялал жуулчлалын байгууллага нь тухайн байгууллагаар үйлчлүүлж буй жуулчны ая тухтай, аюулгүй аялах нөхцөлийг бүрдүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.14 дэх заалтын “... тогтоох” гэсний дараа “... , журам батлах;” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“3.1.1.“аялал жуулчлал гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газар нутагт нэг өдрөөс нэг жилийн хугацаагаар ажиллах болон суралцахаас бусад зорилгоор аялан явахыг;”

2/ 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

“16.1.6.Аялал жуулчлалын байгууллагад ангилал тогтоох, зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох, цуцлах, журам батлах.”

**4 дүгээр зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 9.1 дэх хэсгийн “... бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах тухай гэрээ ...” гэснийг “... бүтээгдэхүүний аялал жуулчлалын гэрээ ...” гэж, 4.1.1 дэх заалтын “аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, сурталчлах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулах;” гэснийг “энэ хуулийн 3.1.2 дахь заалтад заасан үйл ажиллагааг зохион байгуулах;” гэж, 13.1.3 дахь заалтын “...улс...” гэснийг “... төрийн болон албаны ...” гэж, 18.2.2 дахь заалтын “... олгож, гэрээ байгуулах;” гэснийг “... олгож, шийдвэрлэх;” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 10.2 дахь хэсэг, 3.1.8 дахь заалтын “дээд зэрэглэлийн ...” гэснийг, 3.1.6 дахь заалтын “... зэрэг ...” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 2.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны...дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,  
АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“3.1.1. “Гол, мөрний урсац бүрэлдэх эх” гэж Усны тухай хуулийн 3.1.5-д заасныг;”

**2 дугаар зүйл.** Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 3.1.3 дахь заалтын “31.3” гэснийг “22.3” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны...дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.1. Усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, мөрөн, гол, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа газар хамаарна.” гэснийг “15.1. Усны сан бүхий газарт Усны тухай хуулийн 3.1.4–д заасан газар хамаарна.”

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны...дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын хэвлийн тухай хуулийн дараахь зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 18 дугаар зүйл:

“18 дугаар зүйл. Газрын доорх болон гадаргын ус, рашааныг ашиглахдаа Усны тухай хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН  
АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн “3.1.12.“хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс” гэж Усны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-д заасныг;” гэснийг “3.1.12. онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс” гэж Усны тухай хуулийн 3.1.9, 3.1.10-д заасныг” гэж өөрчлөн найруулсугай.

**2 дугаар зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5.1.2 дахь заалтын “... 10.1.4 ...” гэснийг “... 9.1.3 ...” гэж, 17.4.2 дахь заалтын “... 31.3 ... ” гэснийг “... 22.3 ...” гэж , 17.4.4 дэх заалтын “...31.4 ...” гэснийг “... 22.4 ...” гэж, 17.8 дахь хэсгийн “... 31.2.1...” гэснийг “... 22.2.1 ...” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 46 дугаар зүйл:

“5.1.46. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж. “

2/ 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 36, 37, 38 дахь заалт:

“21.1.36. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж Монгол Улсын иргэнээс 500 төгрөг, гадаадын иргэнээс 3000 төгрөг;”

“21.1.37. Анчны болон загасчлах эрхийн үнэмлэхний хураамж 35 000 төгрөг”

“21.1.38. Байгаль орчны аудит хийх эрхийн гэрчилгээний хураамж.....төгрөг

**2 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.1.17 дахь заалтын “...11.1.8, 20.3 ...” гэснийг “... 21.2, 21.4...” гэж, “... 23.1...” гэснийг “... 28.8...” гэж, 5.1.18 дахь хэсгийн “12.1.10” гэснийг “7.1” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 7.7 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/ 7.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу нөхөн сэргээгээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2/ 7.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Байгалийн ургамлын тухай хуулийн 20.2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүсэн, ашигласан, тарималжуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3/ 7.7 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Ургамал ашиглах зөвшөөрлийн эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/ 7.6 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:

“8. Амьтныг тэжээврээр үржүүлэхдээ ашиг шимийг нь нэмэгдүүлэх зорилгоор үржил селекцид оруулж, генийн өөрчлөлттэй болгон байгальд нь буцаан тавьсан тохиолдолд нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**3 дугаар зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/ 7.9 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг:

“12.Мод, модон материалын худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг хүн, хуулийн этгээд нь зөвшөөрөлгүй бэлтгэсэн болон гарал үүслийн гэрчилгээгүй мод, модон материалыг худалдан авсан, тээвэрлэсэн, тээврийн хэрэгслийг худалдаа, үйлчилгээ явуулж байгаа газартаа оруулсан, боловсруулсан, худалдаалсан бол хүнийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. “

2/ 7.9 дүгээр зүйлийн 13 дахь хэсэг:

“13.иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад олгосон мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**4 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ ... гэрээнд заасан ...” гэсний өмнө “... эрхийн бичиг болон ...” гэж, 7.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “ ... зориулалтаар ...” гэсний өмнө “... , судалгаа шинжилгээний...” гэж, 7.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “ ... ашигласан ...” гэсний дараа “... орлого олох зорилгоор бусдад борлуулсан ...” гэж, 7.15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “гол мөрний урсацын байгалийн үндсэн голдирлыг...” гэсний дараа “... зөвшөөрөлгүйгээр ...” гэж, 10.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “...ажиллаагүй ...” гэсний дараа “... , жуулчин хүлээн авах эрхийг тодорхойлсон гэрчилгээг ил байрлуулаагүй ...” гэж тус тус нэмсүгэй.

**5 дугаар зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 7.4 дэх заалтын 1.3 дахь хэсгийн “... хориглосон ...” гэсний дараа “... , агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаасан, зориулалтын бус газарт хог хаягдал хаясан, ил задгай шатаасан, агаар бохирдуулах бодис ялгаруулдаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн, техник технологи нэвтрүүлсэн, материал, бодис, бүтээгдэхүүнийг хэрэглэсэн, урамшуулал бүхий цахилгаан эрчим хүчийг ахуйн зориулалтаас бусад хэлбэрээр ашигласан, стандартын шаардлага хангаагүй цахилгаан халаах хэрэгсэл хэрэглэсэн ...”, гэж, 7.9 дүгээр зүйлийн 6 дугаар хэсгийн “... төлөвлөгөөнд...” гэснийг “...төлөвлөгөө, эрхийн бичигт ...” гэж, 7.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... ашиглах ...” гэснийг “ ... ажиглах ...” гэж, 14.6 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “... тээвэрлээгүй ...” гэсний дараа “... стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулсан ...” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь хэсгийг тус тус хассугай

**6 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр  
сарын ... өдөр

Улаанбаатар  
хот

**ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД  
ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3<sup>1</sup> дүгээр зүйл:

33<sup>1</sup> дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт”

2/“3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.”

3/“3.1.1.“Конвенцийн тал” гэж Конвенцид нэгдэн орсон улсыг;”

4/“3.1.2.“Бага хурлын чуулган” гэж нэгдэн орсон талуудын бага хурлын чуулганыг ;”

5/“3.1.3.“Нарийн бичгийн дарга нарын газар” (цаашид “НБДНГ” гэх) гэж” конвенцийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий конвенцийн 12 дугаар зүйлд заасан байгууллагыг ;”

6/“3.1.4.“Конвенцийн хавсралт” гэж Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 1, 2, 3 дугаар хавсралтыг;”

7/“3.1.5.“Зүйл” гэж аливаа амьтан, ургамлын зүйл, салбар зүйл мөн тэдгээрийн газар зүйн хувьд тусгаарлагдмал бүлийг;”

8/“3.1.6.“Биет” гэж аливаа амьтан ургамлын гаралтай эд зүйл, хэсэг, тэдгээрийн цогцос, үлдэгдэл зүйлсийг;”

9/“3.1.7.“Худалдаа” гэдэг нь экспорт, импорт, реэкспорт, далай тэнгисээс олзворлон оруулж ирэх үйл ажиллагааг;”

10/“3.1.8.“Реэкспорт” гэж урьд нь импортоор оруулж ирсэн аливаа биетийг экспортлож гаргахыг;”

11/“3.1.9.“Далай, тэнгисээс олборлон оруулах” гэж аль ч улс оронд харьяалагддаггүй далай, тэнгисийн орчноос аливаа зүйлийн нөлөөлөх биетийг олзворлон аль нэг улсад тээвэрлэн оруулахыг;”

**2 дугаар зүйл.** Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 1.1.1. дэх заалтын “... тэдгээрийн гаралтай эд зүйл...” гэсний дараа “...болон биетийг...” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “ ... тэдгээрийн гаралтай эд...” гэсний дараа “...биет...” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

”2.1.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж нь Амьтны тухай, Байгалийн ургамлын тухай, Гаалийн



тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

2/5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

“5.1.5.Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг, биетийг реэкспортлох болон далай тэнгисээс олборлон оруулах, конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг, биетийг экспортлоход гэрчилгээ олгох;”

3/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

“6.2.2.Конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамалын зүйл тэдгээрийн гаралтай биетэд экспортын квот тогтоох ба тухайн харилцааг холбогдох журмын дагуу явуулна.”

4/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“9.1.7.тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг, биетийг олж авахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан төлбөр, хураамж тушаасан баримт бичиг.”

5/10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“10.2. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн конвенцийн хавсралтад орсон зүйлээ амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлд хамаарах хувийн хэрэглээний импортлох, эсвэл импорлогч орны зөвшөөрөл шаардагдахаас бусад тохиолдолд экспортлохдоо зөвшөөрөл авахгүй.”

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгалийн ургамлын тухай хуулийн дараахи зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“4.2. Байгалийн ургамлын хамтын менежментийн үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд үүнтэй холбоотой харилцааг байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.”

2/9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“9.2. Нөхөн сэргээх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“13.6. Энэ хуулийн 13.3 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг олгохдоо энэ хуулийн 7<sup>1.4</sup> дэх заалтыг үндэслэнэ.”

4/15 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“15.6. Энэ хуулийн 15.4 дэх хэсэгт заасан эрхийн бичгийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Байгалийн ургамлын тухай хуулийн 8.1 дахь хэсгийн “...ач холбогдол...” гэсний өмнө “... экологийн...” гэж 16.2 дахь хэсгийн “...бэлтгэх...” гэсний дараа “...гадаад улсад гаргах...” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Байгалийн ургамлын тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 1 дахь хэсэг:

“3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөгнөөс бүрдэнэ.”

2/6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг:

“6.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн өмчийн газар дээрх ургамлыг ашиглахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14.1, 14.2 хэсэгт заасны дагуу төлбөр төлнө.”

“6.2.Ургамал ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх асуудлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.”

**4 дүгээр зүйл.**Байгалийн ургамлын тухай хуулийн 7<sup>1.1</sup> дүгээр зүйл “...Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа...” гэснийг, 8.1 дүгээр зүйл “...Байгаль орчны тэнцлийг хангах...” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдан гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

“8.9.Энэ хуулийн 8.4.6-д заасан дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2/ 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

“19.1.5.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг холбогдох хууль тогтоомж зөрчин гаргасан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдвол тухайн дүгнэлтийг гаргасан үнэлгээний шинжээчийн эрхийг хүчингүй болгоно.”

**2 дугаар зүйл.** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “... төслүүдээс ...” гэсний дараа “...байгаль орчин...” гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “...зураг төсөл...” гэсний дараа “...эх загвар зураг...” гэж, “... тодорхойлолт ...” гэсний дараа “... тухайн сав газрын захиргааны санал ...” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1. дэх хэсгийн “...төсөл хэрэгжих...” гэсний өмнө “...Төсөл хэрэгжүүлэгч нь...” гэж, “... байгууллагатай...” гэсний дараа “...хамтран...” гэж, “...боловсруулж...” гэсний дараа “... , хэрэгжүүлнэ...” гэж, 9.14 дахь хэсгийн “...эсэх асуудлыг ...” гэсний дараа “... хуульд өөрөөр заагаагүй бол ...” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 9 дүгээр зүйлийн 15 дахь хэсэг:

“9.15 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “... байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн...” ”

2/ 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 8 дахь заалт:

“8.4.8.төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдэд хийсэн танилцуулга, хэлэлцүүлэгийн тайлан, төсөл хэрэгжих Багийн Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн санал”

3/14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

“14.1.2.тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд батлуулж, биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн

нөлөөлөлд өртөгч талууд, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах”

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дүгээр  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 зүйлд дараах агуулга бүхий заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:

“6.1.14.Монгол улсад ашиглаж болох химийн хорт болон аюултай бодисыг бүртгэх үйл ажиллагааг судалгааны байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг батална.”

**2 дүгээр зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “...Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль ...” гэснийг “ ...Хог хаягдлын тухай хууль ...” гэж, 6 зүйлийн 6.1.1 дахь заалтын “...үйлдвэр худалдааны...” гэснийг “...гадаад худалдааны...” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...сарын  
... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Амьтны тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 27 дахь хэсэг:

“4.27.“Сэлгэн нутагшуулах” гэж амьтны зүйлийн тоо толгойг өсгөх, цус сэлбэх, нягтшлыг сийрүүлэх болон генетикийн солилцоо хийх зорилгоор тархац нутгийн хүрээнд нэг газраас өөр газарт шилжүүлэн байршуулах замаар зориудаар зөөвөрлөн нутагшуулах үйл ажиллагааг,”

2/4 дүгээр зүйлийн 28 дахь хэсэг:

“7.28.”элбэг амьтан” гэж нэн ховор болон ховор амьтнаас бусад тархац нутагтаа бүхэлд нь болон ихэнх хэсэгт элбэг тархсан амьтныг”

3/4 дүгээр зүйлийн 29 дэх хэсэг:

“4.29.“Эрдэм, шинжилгээ” гэдэгт амьтны биеийн бүтцийг судлах, эд, эрхтэнд нь гэмтэл учруулалгүйгээр судалгааны багаж, тэмдэг зүүх, хэмжилт хийх, эд эрхтэнээс сорьц авахыг,”

4/4 дүгээр зүйлийн 30 дахь хэсэг:

“4.30.“Соёл, урлагийн зориулалт” гэдэгт үндэстэн, ястны уламжлалт зан үйл, музейн үзмэр, урлагийн бүтээл, амьтны хүрээлэн, соёлын үзвэрт ашиглахыг,”

5/4 дүгээр зүйлийн 31 дэх хэсэг:

“4.31.“Эмчилгээний зориулалт” гэдэгт эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийн дагуу эмийн үйлдвэрлэл, эмчилгээний зорилгоор гаршуулан үржүүлэх замаар ашиглахыг”;

6/4 дүгээр зүйлийн 32 дахь хэсэг:

“4.32“Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч” гэж тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сумын Засаг дарга, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагатай Амьтны тухай хуулийн 22.5-д зааснаар гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг”

7/4 дүгээр зүйлийн 33 дахь хэсэг:

“4.33.“Зуучлагч байгууллага” гэдэгт спорт агнуур болон олзворын чиглэлийн агнуурыг анчдад зуучлах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг хуулийн этгээдийг”

8/13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“13.2.Ховор, нэн ховор амьтнаас бусад амьтныг өмчлөх журам, гэрээний загварыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

9/15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“15.4.Амьтан ашиглах гэрээний загварыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

10/16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“16.2.Нэн ховор амьтныг зөвхөн судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно”.

11/25 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“25.7.Судалгаа, шинжилгээ, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаас бусад тохиолдолд амьтныг зөвхөн агнуурын бүс нутагт агнаж, барина.”

12/26 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“26.4.Ан амьтан агнах, барих жишиг үнийг Засгийн газар тогтооно”.

13/27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“27.3.Үйлдвэрлэлийн зориулалтаар амьтан агнах, барих гэрээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн гишүүн батална.”

14/28 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“28.6.Гадаадын иргэн энэ хуулийн 28.1.3-т заасан хугацаанд ахуйн зориулалтаар агнах загас нь 10 ширхэгээс илүүгүй байна.”

15/28 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“28.6.Ахуйн зориулалтаар загас барих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”.

**2 дугаар зүйл.** Амьтны тухай хуулийн 5.4.2 дахь заалтын “...амьтны ...” гэсний өмнө “...харъяалах нутаг дэвсгэртээ...” гэж, 7.7.6 дахь хэсгийн “...журмыг гэсний дараа “... шинжлэх ухааны холбогдох байгууллагын саналыг үндэслэн ...” гэж, 9.7 дахь хэсгийн “...агнаж...” гэсний дараа “...барихыг...” гэж, 17.2 дахь хэсгийн “...хэлбэрээр...” гэсний дараа “...нэн ховор болон ховор амьтнаас бусад ан ...” гэж, 20.2 дахь хэсгийн “...зөвшөөрлийг...” гэсний дараа “... шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн...” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Амьтны тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:

“4.1.14.”Иргэний зориулалттай галт зэвсэг” гэж Галт зэвсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг”

2/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь заалт:



“4.1.18.”харь амьтан” гэж тухайн экологийн бүс нутагт түүхэн хугацаанд тэмдэглэгдээгүй, өөр газраас зориудаар болон санамсаргүйгээр зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа амьтны зүйлийг гэж;

3/ 4 зүйлийн 1 дэх хэсгийн 23 дахь заалт:

“4.1.23 “...Ангийн аж ахуй...” гэснийг “...мэргэжлийн байгууллага...” гэж

4/5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт:

“5.3.2.Загнуурын нөөц бүхий аймаг болон агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих”

5/ 6 зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

“6.1.2.нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол Улсын “Улаан ном”, бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад бүртгэх гэснийг “нэн ховор, ховор амьтан, ургамлыг Олон улсын улаан ном болон Монгол Улсын улаан ном бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад бүртгэж хамгаалах.”

6/7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“7.3.Энэ хуулийн 7.2-т зааснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн эд эрхтэнг худалдах, худалдан авахыг хориглоно.”

7/7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалт:

“7.5.2.Тусгай төлбөр төлсөн Монгол улсын болон гадаадын иргэн спорт агнуур болон олзворын ангийн зориулалтаар”

8/9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“9.3.агнуурын амьтны зүйлийн жагсаалт, ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барих хугацаа, ахуйн зориулалтаар зөвшөөрөл олгох журмыг шинжлэх ухааны холбогдох байгууллагын саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална.”

9/9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

“9.7.Энэ хуулийн 7.5.2-д заасан зориулалтаар агнах ховор амьтныг дор дурдсан хугацаанд агнаж, барихыг хориглоно”.

10/10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт:

“10.1.9.гол, мөрөнд моторт завь ашиглан ахуйн болон тусгай зориулалтаар загасчлахыг хориглоно.”

11/ 21 зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт:

“21.3.2.агнуурын нөөцийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан журмыг мөрдөж ажиллах.”

12/21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“21.1.4.агнах амьтан нь тухайн сум, дүүргийн агнуурын бүс нутгаас тухайн жилд агнахаар зөвшөөрөгдсөн амьтдын тоо хязгаар, эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл, гэрээнд заасан тоо хэмжээ дотор багтаж байх”

13/21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь хэсэг:

“21.5.3.агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулахад агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчид дэмжлэг үзүүлэх;”

14/ 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“22.4.Агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, ангийн гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50.4-т заасны дагуу хуулийн этгээдэд эзэмшүүлж болно”.

15/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:

“25.2.Ахуйн болон тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичиг, тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгож болох бөгөөд агнуурын амьтан агнах, барих гэрээ, эрхийн бичиг, тусгай зөвшөөрлийн загварыг төрийн захиргааны төв байгууллага батална”.

16/30 дугаар зүйлийг 1 дэх хэсэг:

“30.1.Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тухайн жилд агнах агнуурын амьтны тоо, хэмжээний дээд хязгаарыг үндэслэн цагдаагийн төв байгууллага иргэний зориулалттай галт зэвсэг, сумны гадаад захиалга, хуваарилалтыг төлөвлөж хэрэгжүүлнэ”

17/ 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“30.2.Иргэний зориулалттай галт зэвсэг, сумыг захиалах, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага хянаж, зохион байгуулна”.

**4 дүгээр зүйл.** Амьтын тухай хуулийн 18.1 дэх хэсгийн “...бугын цусан эвэр...” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Амьтны тухай хуулийн 5.4.7. дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ..... дүгээр  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**“1 дүгээр зүйл.** Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“6.3.Цөлжилтийг сааруулахад дараах нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.”

2/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

“4.1.10. хөрсний шим тэжээлийн бодис” гэж Тариалангийн тухай хуулийн 3.1.4-дэх заалтад заасныг;”

3/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалт:

“4.1.11 “хөрсний үржил шим” гэж Тариалангийн тухай хуулийн 3.1.5 дахь заалтад заасныг;”

4/ 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1-5 дахь заалт:

“6.3.1.Уул уурхайн хайгуул болон ашиглалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх;”

“6.3.2.Хөдөө, орон нутгийн олон салаа замын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх;”

“6.3.3.Говь хээрийн мод, бутлаг ургамлын байгалийн сэргэн ургалтыг дэмжих;”

“6.3.4. Доройтсон бэлчээрийн газрыг сэргээх;”

“6.3.5. Хот, суурин газрыг элсний нүүдлээс хамгаалах;”

5/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“8.1.4.Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх, сааруулах нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн нөөцийг бүрдүүлэх; ”

**2 дугаар зүйл.** Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8.1.2 дахь заалтын “Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах” гэсний дараа “... салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороо, түүний ажлын албыг байгуулж ажиллуулах.” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 10.1 дэх хэсгийн “ ... 46 дугаар зүйлийн 46.1” гэснийг “54 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хувиргасан амьд организмын тухай хуулийн 15.1 дэх хэсгийн “зөрчил гаргасан” гэснийг “зөрчил илрүүлсэн” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“26.7. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам батлах.”

2/ 27 дугаар зүйлийн 12-16 дугаар хэсэг:

“27.12. Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах журмыг батлах.”

“27.13. Байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтын дэглэмд нийцүүлэн горимыг батлах.”

“27.14. Улсын тусгай хамгаалалттай газрын дотоод бүсчлэл тогтоох.”

“27.15. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих.”

“27.16. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бүхэлд нь болон хэсэгчлэн гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журам батлах, гэрээ байгуулах..”

3/ 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“28.4. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг батлах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг орон нутгийн төсөвт тусгах.”

4/ 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“29.4. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах.”

5/ 30 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

“30.11. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг хангах.”

6/ 32 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“32.1. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагчийн хэрэглэх галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29.4 дэх хэсэгт заасны дагуу тогтооно.”

“32.2. Байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29.2 дахь хэсэгт заасан тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно.”

7/ 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“37.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газар ашиглах тухай гэрээг тухайн хамгаалалтын захиргаа болон дүүргийн газрын алба, сумын даамалтай хамтран байгуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.”

**2 дугаар зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 6.2 дахь хэсгийн “... орлого ...” гэсний дараа “нэвтрэх хураамж” гэж, 12.1 дэх хэсгийн “....олборлох” гэсний дараа “геологийн судалгаа хийх, металл хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах, ашиглах ....” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 32.2 дахь хэсгийг хүчингүй болгосугай:

**4 дүгээр зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дүгээр  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 8.1.3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дүгээр  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“6.5. Орчны бүсийн зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2/7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“7.5. Орчны бүсийн сангийн үйл ажиллагааны журмыг санхүүгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

3/8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“8.3. Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 5.5 дахь хэсгийн “... хэлэлцүүлж” гэсний дараа “... аймаг нийслэлийн Засаг даргаар уламжлуулан... ” гэж, 8.1 дэх хэсгийн “... боловсруулан” гэсний дараа “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, ....” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны...дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**“1 дүгээр зүйл.** Усны тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг, 28 дугаар зүйл, 31 дүгээр зүйл, 31.1 дэх хэсэг, 3.1.27, 17.1.6 дахь заалтын “ус” гэсний дараа “... , рашаан ...” гэж, 32.10 дахь хэсгийн “Усны аливаа барилга байгууламж нь паспорттай байна.” гэсний дараа “Уг паспортын загварыг усны барилга байгууламжийн төрлөөр нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.” гэж, 10.1.3 дахь заалтын “... сэргээх” гэсний дараа “өрөмдмөл худаг...”, “...байгууламжийг” гэсний дараа “... шинээр барих, сэргээн засварлах, ...” гэж, “... эзэмших ...” гэсний дараа “нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм ... ” гэж, 17.1.6 дахь заалтын “... цооног өрөмдөх, ...” гэсний дараа “... худаг гаргах, ...” гэж, “... мэдээллийн санд ...” гэсний өмнө “...худгийн паспорт олгох, ...” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Усны тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 22 дугаар зүйл:

“22 дугаар зүйл. “Усны нөөцийг хамгаалах” гэснийг “Ус, рашааны нөөцийг хамгаалах” гэж,

25.2.“байгаль орчны байцаагч” гэснийг “байгаль орчны хяналтын улсын байцаагч” гэж өөрчилсүгэй.

2/30 дугаар зүйл:

“30 дугаар зүйл. “Ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлага” гэснийг “Ус, рашаан ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлага” гэж,

3/10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 23 дахь заалт:

“10.1.23. “ ... хийх, дүгнэлт гаргах.” гэснийг “ ... хийхэд дүгнэлт гаргах. “ гэж,

4/ 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“13.1.4.”мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн ... ” гэснийг “сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн ...” гэж,

5/ 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“17.1.8. “сав газрын хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн болон хаягдал ус зайлуулах цэг тогтоох;” гэснийг “сав газрын хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн болон хаягдал ус зайлуулах цэг тогтооход дүгнэлт гаргах;” гэж.

**3 дугаар зүйл.** Усны тухай хуулийн 22.2.1 дэх заалтын

“... , байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, ... ” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ойн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 23<sup>1</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“23<sup>1</sup>.1.Ойн мэргэжлийн байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу магадлан итгэмжлэлд хамрагдах бөгөөд магадлан итгэмжлэх журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2/ 27 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“27.6.Ойд хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар гүйцэтгэнэ.”

3/ 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“33.3.Ойгоос мод бэлтгэх гэрээ, технологийн карт, эхлэл, төгсгөлийн акт, мод тээвэрлэх хяналтын хуудас, бэлтгэх модны санал ирүүлэх хүснэгтийн загварыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн 34.2, 38.2 дахь хэсгийн “хэмжээ” гэсний дараа “... , ногдуулсан төлбөр” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“7.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг арван жил тутамд явуулж, ойн сангийн төлөв байдлыг шинэчлэн тогтооно”.

2/ 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6 дахь заалт:

“17.3.6.Ойн баялаг ашигласны төлбөр, хураамжийн бүрдүүлэлт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтанд хяналт тавих.”

3/ 21 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:

“21.8.Ойн нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг эзэмших давуу эрхтэй бөгөөд ойн нөхөрлөл байгуулахад Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэгт зааснаас гадна гэрээгээр эзэмших ойн талбайн хилийн цэс, байршил, тархалтын зураг бүрдүүлсэн байна.”

4/ 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“22.3.Энэ хуулийн 21.9 дэх хэсэгт заасан гэрээ болон гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

5/ 42 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“42.4.Ойн баялгийн нөөцийн нөхөн төлбөрийн хэмжээг экологи эдийн засгийн үнэлгээгээр тогтооно.”

**4 дүгээр зүйл.** Ойн тухай хуулийн 3.1.24 дэх заалтын “4.1.10” гэснийг “4.1.14” гэж, 4.4 дэх заалт болон 4.4.1 дэх хэсгийн “нөөцийг” гэснийг “баялгийг” гэж, 4.12-т “... 4.6” гэснийг “4.4.2” гэж, 4.13-т “...төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.” гэж, 17.2.11 дэх заалтын “14.1.2” гэснийг “15.1.4” гэж, 17.2.12 дахь заалтын “14.1.4” гэснийг “15.1.3” гэж, 21.1 дэх хэсгийн “4.9” гэснийг “4.7” гэж, 22.1.3 дахь заалтын “4.9” гэснийг “4.7” гэж, 23.3 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн 29.1.6 дахь заалтын “14.2”, 40.2.2 дахь заалтаас “дагалт” гэсэн үгийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн 4.6 дахь заалт, 46 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.8.1-21.8.5 дахь заалт, 39.2, 39.3 дахь хэсэг, 39.5-ын “39.2-” гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.2.9 дэх хэсгийн “цагдаа, хил хамгаалах байгууллагын” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дараах заалт нэмсүгэй.

**15 дугаар зүйлийн 15.6.8 дахь заалт:**

**“15.6.8. Байгаль орчны аудит хийх”**

**2 дугаар зүйл.** Энэхүү хуулийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ